

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 02 дугаар
сарын 19-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор
зарим тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Тогтоол, журамд дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1 дүгээр зүйл. Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д дор дурдсан агуулгатай хэсэг, хавсралт нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлийн 2.6 дэх хэсэг:

“2.6. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад дараах нэмэлт шаардлагыг тавина:

2.6.1. Ажилтны аюулгүй байдлыг хангасан торон /шилэн/ хаалттай байх;

2.6.2. Бичсэн бичлэгийг 1 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын камертай байх;

2.6.3. Кассын машинтай байх;

2.6.4. Тухайн төрлийн валютыг шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

2.6.5. Гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийг нийтэд ил тод мэдээлэх самбартай байх;

2.6.6. Гадаад валютыг худалдан авах, худалдах тухай бүр гадаад валютыг худалдаж авсан, худалдсан тухай баримтыг хоёр хувь үйлдэж, нэг хувийг харилцагчид өгч, нөгөө хувийг санхүүгийн баримт болгон хадгалах;

2.6.7. Долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээг энэхүү журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж дараа долоо хоногийн эхний хагаст Монголбанкинд, сар тутмын валют арилжааны тухай мэдээг энэхүү журмын 7 дугаар хавсралтын дагуу гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байх.”.

2/. “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 6 дугаар хавсралт:

““Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 6 дугаар хавсралт

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

/долоо хоногоор/

.....сарын.....өдрөөссарынөдрийн валютын арилжааны мэдээ

/ББСБ-ын нэр/

| Д/д | Өдөр | Иргэд, хуулийн этгээдийн аль нь болох | Валют /тус бүрээр / | Ханш | Дүн | | Зориулалт |
|-----|------|---------------------------------------|---------------------|------|-------|--------|-----------|
| | | | | | авсан | зарсан | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал

Овог нэр

Гарын үсэг.....

/тамга/”

3/ “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7 дугаар хавсралт:

““Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7 дугаар хавсралт

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

/сараар/

200... оны ...-р сарын ... өдөр

| | | |
|--------------|----------------|----------------|
| ББСБ-ын нэр: | Утас: | Факс: |
|--------------|----------------|----------------|

| № | Худалдаж авсан | Валютын төрөл /тус бүрээр/ | Ханш | Валютын дүн | Америк долларт хөрвүүлснээр | Төгрөгөөр |
|-------------|-------------------|----------------------------|------|-------------|-----------------------------|-----------|
| 1 | Хуулийн этгээдээс | | | | | |
| 2 | Иргэдээс | | | | | |
| ДҮН | | | | | | |
| Дундаж ханш | | | | | | |
| № | Худалдсан | Валютын төрөл /тус бүрээр/ | Ханш | Валютын дүн | Америк долларт хөрвүүлснээр | Төгрөгөөр |
| 1 | Хуулийн этгээдэд | | | | | |
| 2 | Иргэнд | | | | | |
| ДҮН | | | | | | |
| Дундаж ханш | | | | | | |

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал

Овог нэр

Гарын үсэг.....

/тамга/

2 дугаар зүйл. Хорооны “Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2007 оны 122 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулгатай өөрчлөлт оруулсугай:

“

| № | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ | ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ /ангиллаар/ | | | | |
|-----|------------------------|------------------------------------|--------------------|---------------------|---------------------|------------|
| | | ≤ 50,000.0 | 50,001.0-200,000.0 | 200,001.0-400,000.0 | 400,001.0-800,000.0 | 800,001.0≤ |
| 1.4 | Гадаад валютын арилжаа | 100,000.0 | 150,000.0 | 250,000.0 | 300,000.0 | 350,000.0 |

“

3 дугаар зүйл. Хорооны “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2008 оны 169 дүгээр тогтоолын хавсралтад дурдсан гадаад валютын арилжаа эрхлэх Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоосугай.

“

| № | Үйл ажиллагааны төрөл | Аймгийн төвийн сумаас бусад суманд | Аймгийн төвийн сум | Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум | Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг | Улаанбаатар хотын бусад дүүрэг |
|---|------------------------|------------------------------------|--------------------|---|---|--------------------------------|
| 4 | Гадаад валютын арилжаа | 50,000.0 | | | | |

“

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Валют солих цэг ажиллуулах журам” батлах тухай Хорооны 2008 оны 91 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолоор Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д оруулсан нэмэлт өөрчлөлт, хавсралтууд нь өмнө нь Хорооноос гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллагуудад хамаарна.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тогтоолын 1 дүгээр хавсралтад нэр дурдсан 24 хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлагад 2009 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох журмын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрдүүлж ирүүлэхийг үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны
28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

| № | Хуулийн этгээдийн нэр |
|----|---|
| 1 | "Жисаса" ХХК |
| 2 | "Уран уургач" ХХК |
| 3 | "Нью Евро Ази" ХХК |
| 4 | "Зууны гарц" ХХК |
| 5 | "Уянга-Эрдэнэ" ХХК |
| 6 | "Жоншин" ХХК |
| 7 | "Байт-Ийгл" ХХК |
| 8 | "Их арвижих үйлс" ХХК |
| 9 | "МСВСЦ" ХХК |
| 10 | "Баагий Ажаа" ХХК |
| 11 | "Дэлгэрэх боржин" ХХК |
| 12 | "Мөнгөн цэгц" ХХК |
| 13 | "Мөнгөн тулбага" ХХК |
| 14 | "Арвижих гүүр" ХХК |
| 15 | "Арвижих тив" ХХК |
| 16 | "Батжин нэгдэх үрс" ХХК |
| 17 | "Тунамал алтан зоос" ХХК |
| 18 | "Оорцогийн хөндий" ХХК |
| 19 | "Мөнгөнхөврөлт" ХХК |
| 20 | "Хасэбэ-Интернэшнл" ХХК |
| 21 | "Баянгол зочид буудал" ХК |
| 22 | "Улаанбаатар зочид буудал" ХК |
| 23 | "Эдельвайс" ХХК |
| 24 | Буянт-Ухаа дахь "Чингис хаан олон улсын буудал" Төрийн өмчит ААТҮГазар |